



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 04

Эрдэнэбулган сум

Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн
бүртгэл, мэдээллийг сайжруулах тухай

Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн бүртгэл, мэдээллийн үнэн бодит байдал хангалтгүй, сар бүр хугацаандаа мэдээгээ өгдөггүй, үзлэгийн мэдээллээ тухайн сардаа хавдрын мэдээллийн программд оруулдаггүй зэрэг үйл ажиллагаанаас болж умайн хүзүүний болон хөхний өмөнгийн сар, улирал, жилийн мэдээ тасрах, тайлан, мэдээ зөрөх асуудал удаа дараа дахин давтан гарч байгаа тул умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн бүртгэл, мэдээллийг сайжруулах зорилгоор дараахь үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж ажиллахыг Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, ЭМГ-ын дүн бүртгэлд тус тус даалгасгай. Үүнд:

Нэг. Нэгдсэн эмнэлэг:

- 1.1. Умайн хүзүүний эсийн шинжилгээний хариуг удирдамжинд заасан хугацаанд нь гаргаж, программд мэдээллийг оруулан, эрүүл мэндийн төвүүдэд шуурхай мэдээлж, хүргүүлэх
- 1.2. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс умайн хүзүүний болон хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн мэдээг сар бүр хугацаанд нь авах, хугацаандаа мэдээгээ өгөөгүй эрүүл мэндийн төвүүдтэй холбогдож, мэдээллийг тухайн сард нь багтаан авч нэггэх
- 1.3. Умайн хүзүүний болон хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн мэдээг хавдрын мэдээллийн программд оруулж, мэдээлсэн байдалд сар бүр хяналт тавьж, мэдээллийг сар сард нь программанд оруулж, алдааг тухай бүрд нь засан, тайлан мэдээний зөрүү гаргахгүй ажиллах
- 1.4. Умайн хүзүү болон хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн мэдээг сар бүрийн шуурхай мэдээгээр Эрүүл мэндийн газрын дүн бүртгэлд мэдээлж байх
- 1.5. Хавдрын тайланг хагас жил тутам Эрүүл мэндийн газрын дүн бүртгэлд цахим хэлбэрээр, жилийн эцсийн тайланг цаасаар ирүүлж, тайлагнаж байх
- 1.6. Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн 2012-2017 оны тайланг Эрүүл мэндийн газрын дүн бүртгэлд 2018 оны 7 сарын 01-ны дотор цаасан хэлбэрээр ирүүлж, архивлуулах

Хоёр. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд:

- 2.1. Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн маягтыг үзлэг хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүр зөв хөтөлж, сар бүр эрүүл мэндийн төвийн дүн бүртгэлд хүлээлгэн өгч байх

- 2.2. Дүн бүртгэгч умайн хүзүүний болон хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн маягтыг үзлэг хийсэн эмч нараас сар бүр шалгаж аван, Нэгдсэн эмнэлгийн хавдар бүртгэгчид мэдээлэн, хавдрын бүртгэлийн программд оруулж, мэдээ, тайлангийн алдаа, зөрүү гаргахгүй ажиллах
- 2.3. Дүн бүртгэгч умайн хүзүүний болон хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн жилийн эцсийн тайланг Нэгдсэн эмнэлгийн хавдар бүртгэгчид хугацаанд нь хүлээлгэн өгч байх

Гурав. Эрүүл мэндийн газрын дүн бүртгэл:

- 3.1. Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн мэдээг сар бүрийн шуурхай мэдээгээр Нэгдсэн эмнэлгийн дүн бүртгэлээс авч байх
- 3.2. Хавдрын тайланг хагас жил тутам Нэгдсэн эмнэлгийн хавдар бүртгэгчээс авч, хавдрын мэдээллийн сан үүсгэх
- 3.3. Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн 2012-2017 оны тайланг Нэгдсэн эмнэлгийн хавдар бүртгэгчээс цахим болон цаасан хэлбэрээр авч, мэдээллийн сан үүсгэх, архивлах

ДАРГА



Р.ГАНДИЙМАА